

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ

2022.04.18

Улаанбаатар хот


Зорилго: Байгууллагын соёл, ажлын орчин, ажилтанд үзүүлж байгаа нийгмийн баталгаа, сургалт, дэмжлэг, хамт олон хоорондын харилцаа, хандлага, уур амьсгал, үйл ажиллагаанд сэтгэл ханамж хэр байгаа талаар тодорхойлж, үнэлэлт дүгнэлт хийж, илэрсэн алдаа дутагдлыг арилгах, цаашид сайжруулах зорилгоор “ДБҮЭГ” ТӨҮГ-ын нийт албан хаагчдын дунд явууллаа.

Судалгааны асуулгыг Google Forms ашиглан бэлтгэж цахим хэлбэрээр авсан. Нийт албан хаагчдын 108 ажилтан буюу 69 хувь энэхүү судалгаанд хамрагдсан байна. Судалгааг нийт 11 асуумжаар авсан ба сонголттой 10, нээлттэй асуумж 1 байсан.

Хэлтэс, нэгжүүдийн оролцсон байдал:

Та аль хэлтэс, албанд харьяалагддаг вэ?

106 responses




Нэгдүгээр асуумж: Та өөрийн ажилдаа хэр сэтгэл хангалуун байдаг уу?

Шалгуур	Ажилтнуудын тоо
Сэтгэл хангалуун	59
Сайн	29
Дунд зэрэг	14
Сэтгэл хангалуун бус	4
Нийт	106

1. Та өөрийн ажилдаа хэр сэтгэл хангалуун байдаг вэ?

106 responses




Хоёрдугаар асуумж: Та ажлын байрныхаа тав тухтай байдалд сэтгэл хангалуун байдаг уу?

Шалгуур	Ажилтнуудын тоо
Сэтгэл хангалуун	35
Сайн	45
Дунд зэрэг	19
Сэтгэл хангалуун бус	7
Нийт	106

2. Та ажлын байрныхаа тав тухтай байдалд сэтгэл хангалуун байдаг уу?

106 responses




Гуравдугаар асуумж: Ажлын байрны техник тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй байдалд үнэлгээ өгнө үү?

Шалгуур	Ажилтнуудын тоо
Хангалттай сайн	9
Сайн	39
Анхаарах хэрэгтэй	53
Хангалтгүй	5
Нийт	106

3. Ажлын байрны техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй байдалд үнэлгээ өгнө үү?

106 responses




Дөрөвдүгээр асуумж: Таныг удирдаж байгаа албан тушаалтан таны ажлыг дэмжиж тусалж, идэвхжүүлдэг үү?

Шалгуур	Ажилтнуудын тоо
Хангалттай сайн	26
Сайн	52
Анхаарах хэрэгтэй	19
Хангалтгүй	9
Нийт	106

4. Таныг удирдаж байгаа ажилтан таны ажлыг дэмжиж тусалж, идэвхжүүлдэг үү ?

106 responses




Тавдугаар асуумж: Хэлтэс, алба хоорондын уялдаа холбоонд та сэтгэл хангалуун байдаг уу?

Шалгуур	Ажилтнуудын тоо
Сэтгэл хангалуун	14
Сайн	42
Дунд зэрэг	37
Сэтгэл хангалуун бус	13
Нийт	106

5. Хэлтэс, алба хоорондын уялдаа холбоонд та сэтгэл хангалуун байдаг үү?

106 responses




Зургаадугаар асуумж: Хамт олны уур амьсгалд (харилцаа, хандлага, бие биенээ хүндлэх, туслах) сэтгэл хангалуун байдаг уу?

Шалгуур	Ажилтнуудын тоо
Сэтгэл хангалуун	30
Сайн	54
Дунд зэрэг	20
Сэтгэл хангалуун бус	5
Нийт	106

6. Хамт олны уур амьсгалд (харилцаа, хандлага, бие биенээ хүндлэх, туслах) сэтгэл хангалуун байдаг уу?

106 responses




Долоодугаар асуумж: Ажлын байранд ялгаварлан гадуурхах, бие махбод, сэтгэл зүйн дарамт, бэлгийн дарамт, хүчирхийлэл, заналхийлэлд өртсөн эсэх

Шалгуур	Ажилтнуудын тоо
Тийм	9
Үгүй	97
Нийт	106

7. Ажлын байранд ялгаварлан гадуурхах, бие махбод, сэтгэл зүйн дарамт, бэлгийн дарамт, хүчирхийлэл, заналхийлэлд өртсөн эсэх

106 responses




Наймдугаар асуумж: Та байгууллагаас нийгмийн хангамж, эрүүл мэндийн талаар авч буй арга хэмжээнд сэтгэл хангалуун байдаг уу?

Шалгуур	Ажилтнуудын тоо
Сэтгэл хангалуун	31
Сайн	42
Дунд зэрэг	29
Сэтгэл хангалуун бус	3
Нийт	105

8. Та байгууллагаас нийгмийн хангамж, эрүүл мэндийн талаар авч буй арга хэмжээнд сэтгэл хангалуун байдаг уу?

105 responses




Есдүгээр асуумж: Байгууллагаас зохион байгуулж буй сургалт, хөгжүүлэх арга хэмжээнд сэтгэл хангалуун байдаг уу?

Шалгуур	Ажилтнуудын тоо
Хангалттай сайн	31
Сайн	36
Анхаарах хэрэгтэй	32
Хангалтгүй	7
Нийт	106

9. Байгууллагаас зохион байгуулж буй сургалт, хөгжүүлэх арга хэмжээнд сэтгэл хангалуун байдаг уу?

106 responses




Аравдугаар асуумж: Танай хэлтсийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт, цаг баримтлах байдалд үнэлгээ өгнө үү?

Шалгуур	Ажилтнуудын тоо
Хангалттай сайн	38
Сайн	50
Анхаарах хэрэгтэй	16
Хангалтгүй	2
Нийт	106

10. Танай хэлтсийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт, цаг баримтлах байдалд үнэлгээ өгнө үү?

106 responses



Аравнэгдүгээр асуумж: Та санал, хүсэлтээ бичнэ үү.

1. Автобаазын машинууд хуучирсан, парк шинэчлэлт хийх шаардлагатай. Оффист хэрэглэдэг компьютер, хувилагч зэргийн хүчин чадал сайжруулж, проектортой болгох. Сар улиралд мэргэжлийн хүмүүсээр их цэвэрлэгээ, ариутгал хийлгэдэг болох.
2. Зарим удирдлагын хувьд сэтгэл хангалуун бус байдаг. Удирдлага хүн ажилчдаа дорд үзэх, ялгаварлан харьцах, далдуур муулах, буруу мэдээлэл дамжуулах, камераар хэт хянах нь ёс зүйгүй, сэтгэл зүйн хувьд дарамттай байдаг. Байгууллагын дотоод сүлжээний болон санхүүгийн программ хоцрогдсон, доголдолтой санагддаг.
3. Хамт олны уур амьсгалд анхаарах хэрэгтэй
4. Цагийн асуудал нь сонин байдаг тэр тал дээр анхаарч үзнэ үү
5. Хүний нөөц нэмэх
6. Хэлтсийн даргын хувьд дэмждэг ч гэсэн удирдлагын хувьд ажилтнуудаа дэмждэггүй, хийсэн ажлыг үнэлдэггүй. Зарим удирдлага нь камераар байнга хянадаг. Энэ нь ажлын орчин, ажлаа хийхэд дарамт болдог. Мөн ажилтнуудаа дорд үзэж, ялгаварлан харьцдаг нь удирдлага хүний хувьд ёс зүйгүй үйлдэл гэж бодож байна.
7. Хүний нөөцийн бололцоо муугаас ажлын ачаалал их байна. Зарим нэг хүний тогтвор сууршилгүй ажилдагаас болж нэмэгдэл ажил ихтэй байдаг.
8. Цалингаа нэмэхгүй бол юмны үнэ хаданд гарцан хэцүү бна
9. Удирдлагууд чадамжгүй, мөн удирдлагын орон тоо их байна
10. Та бүхэндээ ажлын амжилт хүсье.
11. Зарим удирдлагууд камераар байнга хянадаг, ажлын дарамт, шахалт их байна.
12. Хүн бүр ёс зүйтэй нэг нэгнээ хүндэлмээр л байдаг даа
13. Бие биенээ хүндэлж баймаар л бна
14. Цалин нэмэх шаардлагатай байна.
15. Маркетинг хөгжүүлэлт дээр анхаарах
16. Амьдралыг минь залгуулдаг ажилтай байлгаж байгаад талархья
17. Маш их баярлалаа
18. Цалин дэндүү бага байна
19. Ажлаасаа удаа дараа маш хоцрох явдал байгаа. Бусдыгаа доош татах хэр зохимжтой байдаг бол? Анхааруулж хэлэх хэрэгтэй гэж бодож байна.

20. Сайн
21. Хамт олныг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулбал их зүгээр байна аа
22. Цалин нэмэх
23. Сайн
24. Хамт олны харилцаа хандлага улам дордож байна. Хов жив маш их ярьцгааж байна. Нэгийгээ муу хэлж, сэтгэл зүйн дарамтанд оруулах явдал их ажиглагддаг болсон байна. Ажлын урам зориг хүн бүхэнд алга.Байгууллагаас ажилчдын сэтгэл санааг дэмжих урамшуулахад анхаарах хэрэгтэй.
25. Хэлтэс, алба хоорондын уялдаа холбоо маш муу байна. 1 ажлын хийхийн тулд маш олон дарга нарт тайлбарлаж байж хийж байна/Анхаармаар байна аа/ Цалин нэмэгдэх үү юмны үнэ дийлдэхээ болилоо. Харуул, жолооч нар бид бүгдтэй адилхан нүүрээр цагаа бүртгүүлмээр байна. Бид хоцролт, эрт явсанаа бүртгүүлж арга хэмжээ авхуулж байгаа нь шударга бус байна./энийг заавал удирдлагуудад хэлж өгнө үү/
26. 1.Хэлтэс, алба хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, 2.аливаа асуудал, гаднын байгууллагатай албан бичгээр сайн харилцах, 3.засварчид, зарим ажилтнуудын ажилд хандах хандлага туйлын хангалтгүй буюу мэргэжилтэй ажилчдын ур чадвар муу, ажилд хүний сэтгэлээр ханддаг,4.өөрийн байгууллагын өмч хөрөнгө, сэлбэг материалын зарцуулалтад өөриймсөг сэтгэлээр ханддаггүй, хэрэглээг хянаж шалгадаггүй зэрэг асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй.

ТАНИЛЦСАН:
ДБҮЭГ-ЫН ЗАХИРАЛ

Б.ИЧИНХОРЛОО

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Т.УУГАНБААТАР

БОЛОВСРУУЛСАН:
ХҮНИЙ НӨӨЦ,
НИЙГМИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН МЭРГЭЖИЛТЭН

Б.ХАЛИУН